



**ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН  
ТОГТООЛ**

2023 оны 08 сарын 22 өдөр

Дугаар 382

Улаанбаатар хот

**Ж.Золзаяаг ажилд томилох тухай**

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 9 дэх хэсэг, 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, 19 дүгээр зүйл, Хөдөлмөрийн тухай хуулийн 65 дугаар зүйлийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Цахим хөгжил, харилцаа холбооны сайдын 2023 оны 01/317 тоот албан бичгээр ирүүлсэн санал, Авлигатай тэмцэх газрын 2023 оны “Хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг хянасан тухай” 05/3288 дугаар албан бичгээр ирүүлсэн дүгнэлт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын даргын 2023 оны 07 дугаар сарын 26-ны өдрийн А/57 дугаар тушаалаар байгуулагдсан “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлыг сонгон шалгаруулах ажлыг зохион байгуулах үүрэг бүхий Ажлын хэсгийн 2023 оны 08 дугаар сарын 15-ны өдрийн дүгнэлтийг тус тус үндэслэн “Мэдээлэл, технологийн үндэсний парк” төрийн өмчит үйлдвэрийн газрын захирлаар Жаргалсайханы Золзаяаг 2023 оны 08 дугаар сарын 22-ны өдрөөс эхлэн томилсугай.

2. Ж.Золзаяатай Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээг холбогдох хууль тогтоомжийн дагуу байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т үүрэг болгосугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ХЭЛТСИЙН  
ДАРГА

Ц.БАЯР-ЭРДЭНЭ